



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 0/БС9

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн хэлтсийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 3,782,920 /гурван сая долоон зуун наян хоёр мянга есөн зуун хорь/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс /Н.Уранчимэг/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс /Н.Уранчимэг/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000825

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын өдрийн даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ний  
*0/359* дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс

№	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Чанар байдал	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ /төгрөгөөр/		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Агаар цэвэршүүлэгч	Хятад	2500м2	2020	ш	шинэ	1	454,455	454,455	Дэлхийн зөн	Хандив
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>							<b>1</b>		<b>454,455</b>		
1	Хивс/эрдэнэт/	монгол	хонины ноос /2м*3м/	2020	ш	шинэ	1	354,546	354,546	Дэлхийн зөн	Хандив
2	Буйдан	монгол	модон /2 хүний/	2020	ш	шинэ	1	910,000	910,000		
3	Буйдан	монгол	модон /1 хүний/	2020	ш	шинэ	1	600,000	600,000		
4	Ширээ	Хятад	модон шилэн нүүртэй	2020	ш	шинэ	1	235,000	235,000		
5	Вакум хаалт	монгол	2 давхар	2020	м2	шинэ	2.66	462,000	1,228,920		
									<b>3,328,466</b>		
<b>Нийт бүртгэх хөрөнгийн дүн</b>									<b>3,782,920</b>		